МОНГОЛ УЛСЫН
АЖ ҮЙЛДВЭР,
ЭРДЭС БАЯЛГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, Нэгдсэн үндэстний гудамж 5/1,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 35 06,
Цахим шуудан: info@mimr.gov.mn,
Цахим хуудас: www.mimr.gov.mn

2025.07.01 № 02/1944

танай ____________-ны №____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Тайлан хүргүүлэх тухай

Монгол Улсын Их хурлын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар туссан зорилт, зорилго, арга хэмжээний хэрэгжилтэд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ыг удирдлага болгон 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг биелэлтийн хамт үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 32 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНБААТАР

ATA14031 9129294
9024120060

1508 09 1360

**МОНГОЛ УЛСЫН**
**АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН**
**ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН**
**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2025 оны 07 дугаар сарын 01 Дугаар 05 Улаанбаатар хот

**Тайлан хэлэлцүүлэх тухай**

Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Удирдлагын зөвлөлийн 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам”-ын дагуу Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хүрээнд туссан зорилт, зорилго, арга хэмжээний биелэлтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн болон холбогдох танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Б.Өнөмөнх танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн хөтөлбөрт аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хүрээнд туссан зорилт, зорилго, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн болон тайланг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоосон хугацаанд нь Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНБААТАР

ATA14031 9129294
9024120060

1508 26 0072

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2025 оны 07 дугээр сарын 01-ний өдөр

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь УИХ-ын 2024 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн хүрээнд үйл ажиллагааны хөтөлбөрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар туссан зорилтын хэрэгжилтийн явцад 2025 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн хүрсэн түвшнийг зорилтот түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, төлөвлөлт, биелэлт болон хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй байсан эсэхэд чанарын үнэлгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төлөвлөсөн зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн 2025 оны 06 дугаар сарын байдлаар ирүүлсэн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд нийт 20, Тэргүүлэх чиглэлийн хүрээнд 21 зорилтын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хяналтад авсан 2 бодлогын баримт бичгийн 41 зорилтыг тус яам толгойлон бусад яам, агентлаг, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ба хэрэгжилт **69,14** хувийн биелэлттэй гэж дүгнэв. Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл. Үүнд:

**Нэг: Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө**

- Эдийн засгийн бодлогын хүрээнд 18 арга хэмжээ 49,4 хувь.
- Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд 2 арга хэмжээ 82,5 хувь.

**Хоёр: Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны хөтөлбөрт**

- Эдийн засгийн тэргүүлэх салбарт реформыг хэрэгжүүлэх бодлогын хүрээнд 11 арга хэмжээ 83,63 хувь.
- Ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангах зорилтын хүрээнд 1 арга хэмжээ 90 хувь.
- Байгалийн баялаг, нөөц байршлыг давуу талд тулгуурласан бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд 8 арга хэмжээ 83,75 хувь.
- Үндэсний орон сууцжуулах бодлогыг Үндэсний баялгийн сантай уялдуулан хэрэгжүүлнэ зорилтын хүрээнд 1 арга хэмжээ 85 хувь хэрэгжсэн байна.

Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээний товчоо

| Зорилго | Зорилтын тоо | Хэрэгжилтийн хувь | | | | | Хэрэгжилт /хувь/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 85-аас дээш | 60-84% | 30-59% | 0-29% | х/б | |
| Нэг:Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө | 20 | 4 | 7 | 2 | 7 | - | 52,75 |
| Хоёр:Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааны хөтөлбөр | 21 | 12 | 9 | - | - | - | 85,53 |
| **Дүн** | **41** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **69,14** |

**Дөрөв. Дүгнэлт**

Монгол Улсын Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжсэн "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө", "Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэл"-ийн хэрэгжилтийн үнэлгээг **69,14** хувиар үнэлэв.

**Тав. Санал, зөвлөмж**

1. Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө, Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын Тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилтын хүрээнд авч хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжихүйц, тодорхой, бодитой тусгах;
2. Зорилтыг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, зарцуулсан хөрөнгө, хүрсэн үр дүнг оновчтой, хэмжигдэхүйц байдлаар тайлагнах, холбогдох баримт нотолгоог тухай бүр цуглуулж тайланд хавсаргах;
3. Тайланг тогтсон хугацаанд бүрэн, үнэн зөв, шуурхай тайлагнаж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх;
4. Төрийн захиргааны удирдлагын газраас хэрэгжилтийн тайланг дотоод нэгжүүд болон харьяа байгууллагуудаас гаргуулж нэгтгэн боловсруулахдаа тухайн зүйл, заалтаар өгөгдсөн үүрэгт хамаарах хэрэгжилтийг оновчтой, тодорхой гаргуулах, холбогдох тушаал, шийдвэр болон албан бичгийн огноо, дугаарыг тодорхой бичих, тайлангийн чанар, утга найруулгыг хянах.

ХЯНАСАН:
ХШҮДАГ-ЫН ДАРГА Б.ӨНӨМӨНХ

БОЛОВСРУУЛСАН:
ХШҮДАГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

| Д/д | ТЕЗ-ийн үр дүн | Хөтөлбөрийн үр дүн | Бодлогын уялдаа | Төсөл, арга хэмжээ | Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хувь | Төсөл, арга хэмжээний хэрэгжилт | Батлагдсан төсөв | Батлагдсан эх үүсвэр | Санхүүжилтийн гүйцэтгэл | Санхүүжилтийн эх үүсвэр | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь он | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин | Гүйцэтгэлийн хувь | Тайлбар | ТЕЗ-ийн үр дүнгийн дундаж | Хөтөлбөрийн үр дүнгийн дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | | | | | | | |
| | 1.4. Уул уурхай салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ | 1.4.1. Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын нөөцийг нэмэгдүүлнэ | АХ-4.2.14, МУХТЖҮЧ-6.3.4, ЗГҮАХ-3.3.1.2 | 1.4.1.1. Агаарын геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгэх | 71% | Агаарын геофизик-2024 төслийн 2025 оны үргэлжлэх ажлын төсөл, төсвийг ЗЕМЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 25 болон 04 дүгээр сарын 14-ний өдрүүдэд хэлэлцээд батлуулах тухай дүгнэлт гарсаны дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны А/135 дугаар тушаалаар 14 546 118 285.00 төгрөгөөр баталсан. Агаарын геофизикийн судалгааны ажлыг гүйцэтгэхээр VH-CFL тээвэрт системээр тоноглогдсон агаарын хөлөг Улаанбаатар хотод Буянт Ухаа нисэх онгоцны буудлаас Өмнөговь аймгийн нисэх онгоцны буудалруу хөдлөхөд бэлэн болоод байна. VH-HFX агаарын хөлөг 06 дугаар сарын 25-ны өдөр Баянхонгор аймгийн нисэх онгоцны буудалд буусан бөгөөд судалгааны нислэг үйлдэх тохиргоог хийж гүйцэтгэн судалгааны нислэгийг эхлүүлэхэд бэлэн болоод байна. Мөн Агаарын геофизик-2024 төслийн хүрээнд нийт 110300т км нислэгийн дата цуглуулах ёстой. Үүнээс 41054т км нислэг үйлдсэнээс чанарын шаардлага хангасан 37813.2т км нислэгийн өгөгдөл нь чанарын шаардлага хангасан байна. 2025.06.15-ны өдрийн байдлаар үйл ажиллагааны төрлөөр нийт 1,487,895,000 төгрөг зарцуулсан. Хүрсэн түвшин 56% | | 0 | 40 | Улсын төсөв | 1. Талбай хамрагдалт | Хувь | 2023 | | 60 | 56 | 71.00% | | 49.45 | 85.5 |
| | | | МУХТЖҮЧ-6.3.4, ЗГҮАХ-3.3.1.2 | 1.4.1.2. Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх | 100% | Монгол орны ашигт малтмалын төрлүүдийг судлан ач холбогдол бүхий төрлийг ялган үнэлгээ өгөх ГАСАМ төслийн үр дүнгийн тайлang аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын тушаалаар хүлээн авсан. Энэ төслөөр Монгол орны нутаг дэвсгэрийн хэмжээнд илрүүлсэн ашигт малтмалын төрлүүдийг судлан үнэлэлт дүгнэлт өгсөн. Судалгааны үр дүнд стратегийн ач холбогдолтой ашигт малтмалыг гарал үүслийн төрлөөр нь 5 үндсэн бүлэг, 11 төрөлд ангилан ялгаж тодорхойлсон байна. Мөн төслийн үр дүнгийн тайланг хүлээн авсан | | 0 | 692 | Улсын төсөв | 1. Хэрэгжих төсөл | Тоо | 2023 | | 1 | 1 | 100.00% | | | |
| | | 1.4.2. Ордуудын ашиглалтыг нэмэгдүүлнэ | МУХТЖҮЧ-4.2.1, 4.2.11, ЗГҮАХ-3.3.3.1 | 1.4.2.1. "Монгол, Францын хамтарсан "Зүүвч-Овоо" уран төсөл" төслийн бэлтгэл ажлыг эхлүүлэх | 100% | Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц улсын Орано майнинг С.А хооронд "Хөрөнгө оруулалтын гэрээ"-нд гарын үсэг зурах эрх олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, тогтоолын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр талууд гарын үсэг зурсан. Мөн уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлсэн | | 0 | 0 | Гадаадын зээл тусламж | 1. Арга хэмжээний хэрэгжилт | Хувь | 2023 | | 100 | 100 | 100.00% | | | 100 |
| | | 1.4.3. Боловсруулах хүчин үйлдвэрийг нэмэгдүүлнэ. | МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ 3.3.1.5 | 1.4.3.1. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл технологийн паркийн дэд бүтцийг байгуулах | 10% | ҮТП-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын явц: Автозам – 53.09%, Төмөр зам (1 салаа) – 97%, Төмөр зам (2 салаа) – 10% (үнэлгээний хороо байгуулагдсан, тендер зарлахаар ажиллаж байна). Ус хангамж, ариутгах татуургын систем – 97%, ҮТП-ийн гадна цахилгаан хангамжийн дэд станц, шугам сүлжээг барьж, байгуулах - 10% (багц №1, багц 2 ажил эхэлсэн, гэрээний дагуу урьдчилгаа санхүүжилт олгосон. Багц №3 тендер зарлагдсан, 2025.07.01-нд нээнэ), газрыг тойруулан хашаа барих – 93%. 2025 онд шинээр төлөвлөгдсөн нэмэлт ажлуудын (үерийн хамгаалалтын далан, мэдээллийн технологийн дэд бүтэц ... гэх мэт) үнэлгээний хороо байгуулагдаж, тендер зарлахаар ажиллаж байна. Харин цахилгаан хангамжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа үргэлжилж байгаа ба 2026 онд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. 2025 оны хөрөнгө оруулалтын тодотголд оруулах санал батлагдаж, батлуулахаар ажиллаж байна. Батлагдсан төсөв 89 600, санхүүжилтын эх үүсвэр Гадаад, дотоодын [illegible] | | 0 | 89600000 | Хосолмол эх үүсвэр | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 60 | 10 | 10.00% | | | 41.27 |

| | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | МУХТЖҮЧ-4.2.11, ЭГҮАХ-1.3.3.2 | 1.4.3.2. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын ил уурхайн баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэл хийх | 90% | Худрийн ил уурхайд мөчлөгт урсгалт тээврийн технологи нэвтрүүлэлт 50%-д, зэрэгсийн тэсрэх бодисын үйлдвэрийн бүтээн байгуулалт 90% д, засвар механикийн заводын ТЭЗҮ боловсруулах ажил 9 7%-д хүрсэн. Баяжуулах үйлдвэрийн өргөтгөл, шинэчлэлийн эхний ээлж /ӨНХ-ийн хүдэр боловсруулах 4-р шугамын өргөтгөл, Хам баяжуулалтын 5-р секцийг 12 сая тн/жил хүчин чадалтай болгох шинэчлэх төслүүд/ 100%-д хүрсэн. | | 0 | 930.7 | Холимог эх үүсвэр | 1. Хэрсний тээвэрт мөчлөгт урсгалт тээврийн технологийг нэвтрүүлэх ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 100 | 100 | 68.00% | |
| | | | | | | | | | | 2. Хүдэр бэлтгэлийн I шугамын шинэчлэлийн барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 100 | 100 | 46.00% | |
| | | | | | | | | | | 3. Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг өтгөрүүлэх технологийг нэвтрүүлэх ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 100 | 80 | 10.00% | |
| | | | | | | | | | | 4 Баяжуулах үйлдвэрийн хаягдлыг хуримтлуулах сан шинээр байгуулах ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 100 | 40 | 46.00% | |
| | | | | | | | | | | 5. Засвар механикийн заводын өргөтгөл, шинэчлэлийн ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 100 | 80 | 33.00% | |
| | | МУХТЖҮЧ-4.2.11, ЭГҮАХ-3.3.1.1 | 1.4.3.3. "Эрдэнэс-Таван толгой" ХК-ийн нүүрс тээврийн конвейерийн системийг ашиглалтад оруулах | 10% | Төслийн нүүрс тээврийн конвейерийн системийн ЭТТХК/202310502 дугаарт тендерийг 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдөр зарласан бөгөөд 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр тендерийг нээн, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Xinjiang Coal Design and Research Institute" компанитай 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ЭТТ-2024/993 дугаарт гэрээг байгуулсан байна. Зураг төсөл боловсруулалтын ажил эхэлсэн байна. | | 0 | 304.6 | Холимог эх үүсвэр | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 100 | 10 | 10.00% | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ 1.3.3.2 | 1.1.3.4. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах | 10% | ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-ийг "ЭҮ" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022.06.23-н хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Зэсийн үнэ 8340 $/тн-ны түвшинд 762 сая ам долларын хөрөнгө оруулалтын төсөвтэй батлагдсан ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжаан Уйгарын ӨЗО-ны Фүкоун мужид Шинжааны өнгөт төмөрлөгийн эх үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж 2024.10.31-ны байдлаар туршилтын ажлыг дуусгасан. "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Техникийн зөвлөлийн 2025.03.07-ны өдрийн хуралдаанаар үйлдвэрлэлийн туршилтын тайланг хүлээн авч, туршилтын үр дүнгээр ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-ийн тодотголыг АҮЭБЯ-ны Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлөөр хэлэлцүүлэхийг дэмжсэн. Үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотголыг АҮЭБЯ-ны дэргэдэх ЭБМЗ-өөр 2025.03.31-ний өдөр хэлэлцүүлэн буцаагдсан ба Зөвлөлөөс өгсөн санал зөвлөмжийн дагуу ЗБХБҮ-ийн ТЭЗҮ-ийн тодотголд засварлан боловсруулж "Эрдэнэс Монгол" ХХК-д 2025.05.07-ны өдөр хүргүүлсэн. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн "Нэгдлийн үйлдвэрлэл, | | 0 | 804.77 | Улсын төсөв | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 30 | 10 | 10.00% | ТЭЗҮ-ийн тодотгол батлагдаагүй байгаа тул технологийн түвшний үнэлгээний тайланг ТЭЗҮ-н тодотгол, шинэчлэх ажил хүлээгдэж байна. | | |
| | | | МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ-3.3.1.1 | 1.4.3.5. Дорноговь аймагт "Алтанширээт" үйлдвэрлэл технологийн парк байгуулах | 81% | "Инфинити спэйс" ХХК ("Болдтөмөр Ерөө гол" ХХК)-ийн хэрэгжүүлж буй "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд 1-1.5 сая тонн хүчин чадалтай төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр болон нүүрс баяжуулах үйлдвэр, 1.0-2.0 сая тонны хүчин чадалтай коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр, ширэмний үйлдвэрийг тус тус барьж байгуулахаар төлөвлөж МУ-ын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ын дагуу Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхэлж буй "Инфинити спэйс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Билэгсайхан нар "Татвар төлөх хугацаа сунгах, хэсэгчлэн төлүүлэх гурван талт гэрээ"-г 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу паркийн бүтээн байгуулалтад шаардагдах 183 нэр төрлийн 760 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн 39.0 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 81.9 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жилээр сунгаж, татвар төлөх хугацааг сунгасан. Энэ хүрээнд бүтээн байгуулалтын нийт ажлын гүйцэтгэл 2025 оны 6 дугаар сарын байдлаар 75%-тай байна. Үүнд: 1/Бор хөөвөр болон Долоодын говиос гүний ус дамжуулах 103 км урттай шугамын трассын | | 0 | 110.5 | Холимог эх үүсвэр | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 80 | 73.5 | 81.00% | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | МУХТЖҮЧ-4.2.11, ЭГҮАХ-3.3.1.1 | 1.4.3.6. Дорноговь аймагт "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах | 78.3% | "Си Өү Эй Эл" ХХК-ийн хэрэгжүүлж буй "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд жилд 3 сая тонн хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэр, жилд 600 мянган тонн металлургийн кокс үйлдвэрлэх хүчин чадалтай кокс, эрчим хүчний үйлдвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулахаар төлөвлөх МУ-ын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ын дагуу Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхэлж буй "Си Өү Эй Эл" ХХК-ийн гүйцэтгэх захирал О.Будгэрэл нар "Татвар төлөх хугацаа сунгах, хэсэгчлэн төлүүлэх гурвалсан гэрээ"-г 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу паркийн бүтээн байгуулалтад шаардагдах 1915 нэр төрлийн бараа материалаас 2025 оны 06 дугаар сарын байдлаар 231 нэр төрлийн бараа материалыг 95,941 сая төгрөгөөр импортлон авч Зүүнбаян-Ханги хүртэлх 22.6 км салбар төмөр зам, 3 сая тонны хүчин чадалтай Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын үндсэн бүтцийн ажил болон өтгөрүүлэгчийн барилга, тоног төхөөрөмжийн угсралт, цахилгаан холболт, ачилт буулгалтын талбай, нүүрсний агуулахыг барьж дуусган ашиглалтад оруулахад бэлэн болгосон бөгөөд ҮТП-ийн бүтээн байгуулалтын ажлын төсөвт 150,000 гүйцэтгэл 78,8%-тай байна. | | 0 | 59 | Холимог эх үүсвэр | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 80 | 55 | 78.80% | |
| | | | МУХТЖҮЧ-4.2.11, ЭГҮАХ 1.3.5.2 | 1.4.3.7. Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах | 10% | Дархан Сэлэнгийн бүс нутагт Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлж болохуйц 10 байршлыг судлан "Энх тал" зэрлэгийн дэргэдэх талбайд байгуулсан тохиолдолд үүсэх хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор Инженер-Геологийн урьдчилсан судалгааны ажлыг тухайн газарт хийж гүйцэтгээд байна. Энэхүү судалгааны ажлын үр дүнд дээрх газар Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлэхэд онцгой хүндрэл бэрхшээл байхгүй болох нь тогтоогдсон. Цаашид тус байршлын дэд бүтцийн боломж, өртөө, зэрлэг байгуулах боломж зэргийг холбогдох байгууллага болох Зам тээврийн яамтай зөвшилцсөний үндсэн дээр эцсийн координатыг тодорхойлж 2025 оны 2-р улиралд багтаан газрыг улсын тусгай хэрэгцээнд авахуулахаар ажиллаж байна. Ганлийн цогцолборын ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан бэлэн болсон. Гэвч төслийн хүчин чадлын тухайд боломжит хөрөнгө оруулагчтай хамтран тогтоох шаардлага байгаа тул тендер сонгон шалгаруулалтыг түр хугацаанд хойшлуулаад байна. 2025 оны 2-р улиралд багтаан төслийн стратегийн хамтрагч, түншийг сонгон ЗГ-т танилцуулах ба ингэснээр ТЭЗҮ-ийг хамтран боловсруулах боломж бүрдэнэ. 2025 оны 4-р улиралд багтаан ТЭЗҮ-ийг АҮЭБЯ-ний дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр батлуулахаар төлөвлөж байна. "Эрдэнэс Монгол" ХХК-ийн эүгээс Ган | | 0 | 228 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 10 | 0.5 | 10.00% | |
| | | | МУХТЖҮЧ-4.2.11, ЭГҮАХ-3.3.1.6 | 1.4.3.8. Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах төслийг үргэлжлүүлэх | 42% | Төслийн EPC-2, EPC-3 багцын барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, машин техник, тоног төхөөрөмжийг гаалийн түр горимоор оруулах, ерөнхий гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлийн төлбөрийн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг тухай бүр Сангийн яамханд хүргүүлж ажиллав. 2025 оны 6 сарын 23-ны байдлаар 222 хүсэлтийг хүргүүлсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар багц тус бүрийн гүйцэтгэл дараах явцтай байна. Үүнд: EPC-01 буюу Иргэний байгууламж-100%, EPC-02 буюу Анхдагч технологийн болон дагалдах байгууламжууд – 3,.8%, EPC-03 буюу Дулааны цахилгаан станц-24,3%, EPC-04 буюу Лицензит байгууламжууд – 8,0%, төслийн гүйцэтгэл нийлбэр дүнгээр 27,1%-тай байна. | | 0 | 449.92 | Гадаадын зээл тусламж | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 49 | 27.1 | 42.00% | |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ 3.3.1.6 | 1.4.3.2. Газрын тос дамжуулах хоолой байгуулах төслийг үргэлжлүүлэх | 71% | Газрын тос боловсруулах үйлдвэрийг дотоодын түүхий эдээр хангах 530 км урттай дамжуулах хоолойн барилга угсралтын ажил 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 82,0%-ийн гүйцэтгэлтэй, ажлын явц дараах явцтай байна. Үүнд: Шугам хоолойг сувгийн дагуу байрлуулах ажил- 526.446км, Хоолойн гагнуурын ажил - 517.082км, Дамжуулах хоолойн ухмалын ажил - 372.150км, Дамжуулах хоолой буулгах ажил - 368.787км, Дамжуулах хоолой булах ажил - 352.450км. Үйл ажиллагааны зардалд 301.000.000 төгрөг байна. | | 0 | 445.92 | Гадаадын зээл тусламж | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 100 | 82 | 71.00% | |
| МУХТЖҮЧ-4.2.1, ЗГҮАХ 3.3.1.10 | 1.4.3.10. Алт цэвэршүүлэх үйлдвэрийн бүтээн байгуулалтын төслийг эхлүүлэх | 10% | Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажилд оролцохоор өмнө сонирхлоо илэрхийлж байсан гадаад, дотоодын 13 компанитай тус яамнаас 2025 оны 02 дугаар сараас дахин холбогдож, тус үйлдвэрийн хүчин чадлыг жилд 20 тн алт, 30 тн мөнгө цэвэршүүлэх, өөрийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр тус үйлдвэрийг барьж байгуулах, тодорхой хугацаанд ажиллуулах саналыг хүлээн аваад байна. Төслийн оролцогч талуудтай хууль эрх зүйн болон төсөл хэрэгжүүлэх хэлбэр, нөхцөлийн талаар зөвшилцөх ажил хийгдэж байна. Мөн Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/119 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна<br>Ажлын хэсэг нь уг төслийг хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөл, бусад тавигдах шаардлагыг хангахуйц санал ирүүлсэн гадаадын 2 компани /Холбооны бүгд Найрамдах Герман Улсын Kores & EMH Group, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Temarise Gold Refining Limited/-ийн ирүүлсэн саналыг нарийвчлан судлах, техник-технологи, хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөлийг нарийвчлан тохиролцох, цаашид төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллах, төслийг хэрэгжүүлэх ажлыг хэлэлцээрийн шатанд оруулахаар зорин | | 0 | 0 | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 1. Арга хэмжээний хэрэгжилт | Хувь | 2023 | | 100 | 10 | 10.00% | |
| МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ 3.3.1.13 | 1.4.3.11. Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт орших "Дорнын баялаг" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэн байгуулах Нүүрснээс дизелийн түлш боловсруулах цогцолбор төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх | 10% | Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах үүрэг бүхий зөвлөлийн 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн ҮТП/2024/01 дугаар хурлаар "Дорнын чулуулаг" ХХК-ийн захиалгаар БНХАУ-ын "Седин Инжиниринг" ХХК-ийн боловсруулсан Сүхбаатар аймгийн Асгат сумын нутагт байгуулагдах "Дорнын баялаг үйлдвэрлэл, технологийн парк"-ийг түшиглэн байгуулах 100 мян тн/жил хүчин чадалтай "Нүүрснээс дизель түлш боловсруулах цогцолбор үйлдвэр"-ийн ТЭЗҮ-г хэлэлцэж, хүлээн авсан. Одоогийн байдлаар тус ҮТП-ын газрын асуудал шийдэгдээгүй байгаа тул бүтээн байгуулалтын ажлууд хүлээгдэж байна. | | 0 | 315 | Холимог эх үүсвэр | 1. Төслийн хэрэгжилт | Хувь | 2023 | | 20 | 2 | 10.00% | |
| МУХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ 3.3.1.13 | 1.4.3.12. Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх | 50% | Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах туршилтын үйлдвэрийн ТЭЗҮ-ийг ЭБМЗ-ийн 2023.12.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Тус төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг АҮЭБЯ-ны сайдын 2025 оны 04 сарын 01-ний өдрийн А/72 тоот тушаалаар байгуулж 2025 оны ажлын төлөвлөгөөг боловсруулан бүтээгдэхүүн, зах зээлийн судалгаа, технологийн түвшний үнэлгээ, технологийн боломжит хувилбаруудыг тодорхойлох, технологи нийлүүлэгчдийн судалгаа болон уулзалт хэлэлцээр, хамтран ажиллах, туршилтын дээж илгээх, хагас үйлдвэрлэлийн туршилтыг явуулах, технологи нийлүүлэгчийн сонголтыг хийх зэрэг үндсэн суурь судалгаануудыг хийж гүйцэтгэн бэлтгэл ажлыг хангаж ажилласан. | | 0 | | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 20 | 5 | 50.00% | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | МУХТЖҮЧ 4.2.1, ЗГҮАХ 3.3.1.5 | 1.1.3.13. "Бор Өндөр" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн Жонш боловсруулах цогцолборыг эхлүүлэх | 70% | Жонш баяжуулах үйлдвэрийн БНХАУ-д хийлгэсэн технологийн туршилтын тайлант 2025 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр хүлээн авсан ба уг тайланд үндэслэн "Жонш баяжуулах үйлдвэр"-ийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж, АУЭБЯ-ны ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна. Жонш баяжуулах үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ хийх гүйцэтгэгчийн ажлын даалгаврыг "Эрдэнэс УТП" ХХК боловсруулж, "Эрдэнэс Монгол" ХХК нь баталгаажуулан 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр нээлттэй сонгон шалгаруулалт зарлан, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр гүйцэтгэгчээр Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв шалгарч хийж гүйцэтгэсэн. Мөн БОННҮ боловсруулах ажил "Эрдэнэс УТП" ХХК-ийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төсөвт төлөвлөгдсөн ба 2025 оны III-р улиралд багтаан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахаар ажиллаж байн | | 0 | 100 | Гадаадын зээл тусламж | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 10 | 7 | 70.00% | | | |
| | | | МУХТЖҮЧ 4.2.11, ЗГҮАХ 1.3.4.1 | 1.4.2.14. "Таван толгой" үйлдвэрлэл, технологийн парк түшиглэсэн Кокс-химийн цогцолбор үйлдвэрийн бэлэн байдлыг хангах | 86.25% | "Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай" Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын дагуу "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт "Norinco International Cooperation" Ltd шалгарч 2022 оны 4 дүгээр сарын 14-нд EPC гэрээг байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр тус үйлдвэрийн анхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, туршилт, тохируулгын ажлыг эхлүүлсэн. Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зөвлөлийн 2025.05.16-ны өдрийн хуралдаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Таван толгойн нүүрсний ордыг түшиглэн барих Кокс-эрчим хүчний үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн авсан. | | 0 | 742[illegible] | Төр, хувийн хэвшлийн түншлэл | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 50 | 34.5 | 86.25% | | | |
| | | | МУХТЖҮЧ 7.3.4, ЗГҮАХ 3.3.1.9 | 1.4.2.15. Газрын тосны бүтээгдэхүүний 2.5 сарын хэрэгцээний нөөц бүрдүүлэхэд шаардлагатай улсын нөөцийн шатахууны агуулахын барилга байгууламжийг ашиглалтад оруулах | 0% | Сангийн яамнаас 2024.08.1[illegible]-ны өдрийн 01/[illegible]711 дугаар албан бичгээр ирсэн чиглэлийн дагуу улсын нөөцийн шатахууны агуулах барих төслийн ТЭЗҮ, зураг төсөвт шаардагдах санхүүжилтийг Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад тусгуулах хүсэлтийг тус яамнаас сайдын 2024.08.23-ны өдрийн 01/248 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. Үүний дагуу Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024.09.06-ны өдрийн А/08 дугаар тушаалаар холбогдох төсвийг батласны дагуу Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн агуулахын жишиг нэг маягийн зураг төсөв боловсруулах ажлын сонгон шалгаруулалтыг зохион байгуулж өгөх тухай хүсэлтийг тус яамны ТНБД-ын 2024.10.04-ний өдрийн 03/590 дугаар албан бичгээр Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Гэвч тухайн сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгж хугацаандаа гэрээ байгуулаагүйн улмаас сонгон шалгаруулалт амжилтгүй болсон. Иймд агуулахын зураг төсөв, ТЭЗҮ боловсруулах сонгон шалгаруулалтыг дахин зарлах өгөх тухай хүсэлтийг 2025.01.15-ны өдрийн 02/99 дугаар албан бичгээр ЭЗХЯ-нд дахин хүргүүлсэн бөгөөд сонгон шалгаруулалт дахин зарлагдаагүй байна. Үүнээс гадна агуулахын барилга байгууламжийг барих, ашиглалтад оруулах ажлыг хариуцах нэгж шаардлагатай болсон тул Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулга бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2025.03.19-ний | | 0 | 525 | Улсын төсөв | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 10 | 0 | 0.00% | Төсөв батлагдаагүй, хүлээлттэй, эрчимжүүлэх шаардлагатай | | |
| | | | | | | **ХОЁР. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2.1. Орон нутгийн эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлэх | 2.1.1. Орон нутгийн бие даасан байдлыг нэмэгдүүлнэ. | ЗГ/ХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ 1.3.6.3 | 2.1.1.3. Зүүн бүсийг [illegible] бүстэй интеграцчилан хөгжүүлэх, [illegible] бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн паркийг байгуулах ажлыг эхлүүлэх | 75% | Засгийн газраас Зүүн бүсийг Говийн бүстэй интегрецчилан хөгжүүлэх хүрээнд зүүн болон говийн бүсийг аж үйлдвэрийн тэргүүлэх бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс болгон хөгжүүлэх зорилт тавьж байна. Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн хөгжлийн бодлогыг уялдуулах, нэгтгэсэн байдлаар шинэчлэн тодорхойлох, "Зүүн болон Говийн бүсийн хөгжил-2040" хөтөлбөр, бүсийн зөвлөлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд, бүсийн онцлог, харьцуулалт, тээвэр логистик, тулгамдсан асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах байна. Энэ хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан Говийн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар тээвэр логистикийн төв, хуурай боомтыг Даланзадгад, Чойрт, соёл, аялал жуулчлалын түлхүүр бүс, геопаркыг Дундговь аймагт байгуулахаас гадна говийн бүсийг усаар хангах "Орхон - Онги", Хэрлэн тооно" төслийг үе шаттай хэрэгжүүлэх Засгийн газрын [illegible] энэ чиглэлээр тодорхой [illegible] байна. Түүнчлэн, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтын зорчигчийг өхнүүлэх, [illegible] хүчин чадлыг сайжруулах, Өмнөговь аймагт нүүрс-эрчим хүч болон металлургийн кокс, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсэд барилгын материал, түүхий эдийн | | 0 | 175.79 | Шууд хөрөнгө оруулалт | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 20 | 15 | 75.00% | | 82.5 | 75 |
| | | 2.1.2. [illegible] орон нутагт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. | ЗГ/ХТЖҮЧ-4.2.11, ЗГҮАХ 1.3.4.1 | [illegible] | 90% | "Нүүрс баяжуулах үйлдвэрийн цогцолбор байгуулалтын тухай" Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын дагуу "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт "Norinco International Cooperation" Ltd шалгарч 2022 оны 4 дүгээр сарын 14-нд EPC гэрээ байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр тус үйлдвэрийн анхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, туршилт, тохируулгын ажлыг эхлүүлсэн. Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нягтлан техник, эдийн засгийн [illegible] 2025.05.10-ны өдрийн хуралдаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт [illegible] Кокс [illegible] үйлдвэрийн техник, эдийн засгийн [illegible] хүлээн авсан | | 0 | 273.[illegible] | Шууд хөрөнгө оруулалт | 1. Барилгын ажлын гүйцэтгэл | Хувь | 2023 | | 20 | [illegible] | 90.00% | | | 90 |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ХЯНАСАН
ХЭЛТЭС-ИЙН ДАРГА Б.ӨНӨМӨНХ

ҮНЭЛГЭЭ БОЛОВСРУУЛСАН
ХЭЛТЭС-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

| Д/д | Тэргүүлэх чиглэл | Зорилго | Зорилт | Биелэлтийн хувь | Биелэлт | Тэргүүлэх чиглэлийн дундаж | Зорилгын дундаж |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1.2. Эдийн засгийн тэргүүлэх салбарт реформыг хэрэгжүүлнэ. | 1.2.2 Уул уурхайн тусгай зөвшөөрлийн олголт, уул уурхайн бүтээгдэхүүний ашиглалт, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх цогц реформыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: | 1.2.2.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалдаг бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, биржийн тогтолцоог бэхжүүлнэ. | 90% | Өнөөгийн байдлаар уул уурхайн бүтээгдэхүүнийг спот, форвард гэрээний дагуу биржээр дамжуулан арилжиж байгаа бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийг дуустал 45.6 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг нийт 17.9 их наяд төгрөгөөр арилжаалсан байна. "Монголын хөрөнгийн бирж" ХК-д бүртгэлтэй уул уурхайн бүтээгдэхүүний худалдагч 21 компани, 472 гэрээ байгуулсан худалдан авагчид бүртгэлтэй байна. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаагаар хамгийн их бүтээгдэхүүн арилжсан сар нь 2024 оны 04 дүгээр сард бөгөөд нийт 58 удаагийн арилжаагаар 4.36 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 1.78 их наяд төгрөгөөр арилжаалсан байна. 2025 оны 06 дугаар сарын байдлаар 2.1 сая.тн нүүрс, 2.8 сая.тн төмөр, 0.015 сая.тн зэс, 0.015 сая.тн хайлуур жонш тус тус биржээр арилжсан. | 83.6 | 83.6 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | | | 1.2.2.2. Уул уурхайн тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагааг ил тод, олон нийтэд нээлттэй болгоно. | 100% | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/102 дугаар тушаалаар “Сонгон шалгаруулалтын журам”-ыг шинэчлэн баталж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 7084 дугаартай бүртгүүлсэн.<br>“Сонгон шалгаруулалтын комиссын бүрэлдэхүүнийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/33 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. Мөн журам батлагдсантай холбоотой сонгон шалгаруулалтын ажлыг 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлүүлсэн. Нийт 11 удаагийн сонгон шалгаруулалтын багц зарлаж, 6 удаагийн сонгон шалгаруулалтыг амжилттай зохион байгуулж, 177,3 мян.га талбайд 35 хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож улсын төсөвт 55.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн. | | |
| 3 | | | 1.2.2.3. Зөөвч-Овоо ордын ураны олборлолт, хүдрийн баяжмал боловсруулах үйлдвэрийн төслийг эхлүүлнэ. | 100% | Монгол Улсын Засгийн газраас Хөрөнгө оруулалтын гэрээ төсөлтэй холбогдуулан Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2024.11.21-ний өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулсан. Монгол Улс, Бүгд Найрамдах Франц Улс хамтран "Зөөвч-Овоо" ураны ордыг ашиглах Хөрөнгө оруулалтын гэрээний төсөлтэй холбогдох Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг орлуулах тухай УИХ-ын тогтоолын төслийг 2025.01.09-ний | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өдрийн 01 дугаар тогтоолоор батлуулсан. Улмаар Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц улсын Орано майнинг С.А хооронд “Хөрөнгө оруулалтын гэрээ”-нд гарын үсэг зурах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын 2025.01.14-ний өдрийн 19 дүгээр тогтоолоор батлуулсан бөгөөд уг тогтоолын дагуу Хөрөнгө оруулалтын гэрээнд 2025.01.17-ны өдөр талууд гарын үсэг зурсан байна. Монгол, Францын хамтарсан "Бадрах Энержи" ХХК-ийн хөрөнгө оруулагч БНФУ-д бүртгэлтэй Орано майнинг энгийн хувьцаат компанитай Хөрөнгө оруулалтын гэрээнд 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр талууд гарын үсэг зурж, байгуулсан. Уг хөрөнгө оруулалтын гэрээ хүчин төгөлдөр болж, төсөл эхлүүлэхэд шаардлагатай "Орд ашиглах гэрээ", "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-нүүдийг шинэчлэн байгуулахтай холбоотойгоор ажлын хэсгийн хурал, хэлэлцээрүүдийн ажил хийгдэж байна. | | |
| 4 | | | 1.2.2.4. Үйлдвэрлэл, технологийн парк байгуулах хүрээнд нүүрс-хими, кокс-химийн үйлдвэр, гангийн үйлдвэр, зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах 2 дахь үйлдвэрийн байршлыг эцэслэн тогтоож, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, | 60% | Зэс хайлуулах хоёр дахь үйлдвэрийн байршил тогтоох, дэд бүтцийн нарийвчилсан ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай хөрөнгийн задаргаа хийж, холбогдох мэдээллийн хамт ЭЗХЯ-нд 2025.01.30-ны өдөр хүргүүлсэн. ЭЗХЯ-д зэс хайлах үйлдвэр барих төслийн өмнө хийгдсэн ажлуудын талаарх танилцуулга, мэдээллийг цахимаар хүргүүлээд ЭЗХЯ-ны судалгаа хөгжүүлэлтийн хэлтсийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | технологийн парк байгуулах төслийн газар зүйн байршлыг тогтоож, төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааг эхлүүлнэ. | | мэргэжилтнүүдтэй 2025.02.12-ны өдөр уулзалт хийсэн. Эдийн засаг, хөгжлийн яаманд “Дэмжлэг хүсэх тухай” 2025.02.14-ний өдрийн 01/492 албан бичиг хүргүүлсэн. (Судалгаа, ТЭЗҮ боловсруулахад шаардагдах төсөв шийдвэрлүүлэхээр) | | |
| 5 | | | 1.2.2.5. Газрын тос боловсруулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, түлш шатахууны стандарт "Евро 2"-оос "Евро 5"-руу шилжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ. | 80% | Төслийн EPC-2, EPC-3 багцын барилга угсралтын ажилд шаардлагатай бараа материалыг албан татвараас чөлөөлүүлэх, машин техник, тоног төхөөрөмжийг гаалийн түр горимоор оруулах, ерөнхий гүйцэтгэгчдийн ажлын гүйцэтгэлийн төлбөрийн санхүүжилтийн эрх нээлгэх хүсэлтийг тухай бүр СЯ-нд хүргүүлж ажиллав. 2025.06.23-ны байдлаар 222 хүсэлтийг хүргүүлсэн байна. Төслийн бүтээн байгуулалтын ажил 2025.06.01-ний өдрийн байдлаар багц тус бүрийн гүйцэтгэл дараах явцтай байна. Үүнд: EPC-01 буюу Иргэний байгууламж-100%, EPC-02 буюу Анхдагч технологийн болон дагалдах байгууламжууд – 3,.8%, EPC-03 буюу Дулааны цахилгаан станц- 24,,3%, EPC-04 буюу Лицензит байгууламжууд – 8,0%, төслийн гүйцэтгэл нийлбэр дүнгээр 27,1%-тай байна. 2025.05.31-ний өдрийн байдлаар улсын хэмжээнд нийт 1.14 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортолсноос бүх төрлийн шатахуун 1.06 сая тонн байна. Үүнээс К5 /Евро-5/ ангиллын шатахуун 184.3 мян тонн буюу нийт шатахууны 17 хувийг эзэлж байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад /Евро-5/ ангилалын шатахууны нийт | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | импорт 21.2 мян.тонноор өссөн үзүүлэлттэй байна. Евро-5 ангиллын автобензинийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд өөрийн харъяа авто бааз болон хөдөө орон нутгийн үйлчилгээнд хэрэглэж буй түлш, шатахууны худалдан авалтын сонгон шалгаруулалтыг зарлахдаа зөвхөн экологийн өндөр ангилал бүхий Евро-5 стандартад нийцсэн автобензин, дизель түлш сонгох шаардлага тавьж, гэрээ байгуулах, хэрэглээ, худалдан авалтыг тогтмол нэмэгдүүлэн хамтран ажиллах хүсэлтийг тус яамны ТНБД-ын 2025.01.27-ны өдрийн 02/231 дугээр албан бичгээр "Засгийн газрын авто бааз" ТӨҮГ болон Нийтийн тээврийн бодлогын газарт тус тус хүргүүлсэн. Мөн газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын "Роснефть" компанид Евро-5 ангиллын шатахууны хэрэглээтэй холбоотой хүсэлтийг 2025.02.06-ны өдрийн 01/363 дугаар албан бичгээр, "Газпром" компанид 2025.02.17-ны өдрийн 02/515 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. | | |
| 6 | | | 1.2.2 6. Алт цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг эхлүүлнэ | 80% | Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажилд оролцохоор өмнө сонирхлоо илэрхийлж байсан гадаад, дотоодын 13 компанитай тус яамнаас 2025 оны 02 дугаар сараас дахин холбогдож, тус үйлдвэрийн хүчин чадлыг жилд 20 тн алт, 30 тн мөнгө цэвэршүүлэх, өөрийн хөрөнгө оруулалт, санхүүжилтээр тус үйлдвэрийг барьж байгуулах, тодорхой хугацаанд | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллуулах саналыг хүлээн аваад байна. Төслийн оролцогч талуудтай хууль эрх зүйн болон төсөл хэрэгжүүлэх хэлбэр, нөхцлийн талаар зөвшилцөх ажил хийгдэж байна. Мөн Алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/119 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байна. Ажлын хэсэг нь уг төслийг хэрэгжүүлэхээр хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөл, бусад тавигдах шаардлагыг хангахуйц санал ирүүлсэн гадаадын 2 компани /Холбооны бүгд Найрамдах Герман Улсын Koras & EMH Group, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Temarise Gold Refining Limited/-ийн ирүүлсэн саналыг нарийвчлан судлах, техник-технологи, хөрөнгө оруулалт, төлбөрийн нөхцөлийг нарийвчлан тохиролцох, цаашид төр-хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран ажиллаж, төслийг хэрэгжүүлэх ажлыг хэлэлцээрийн шатанд оруулахаар зорин ажиллаж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | | | 1.2.2.7. Уул уурхайн нөхөн сэргээх ажлын хяналтыг сайжруулж, хариуцлагатай уул уурхайг дэмжинэ. | 80% | Ашигт малтмалын тухай хуулийн төслийг УИХ-аас томилогдсон ажлын хэсэгт 2024 оны 11 дүгээр сарын 27-ний өдөр танилцуулсан. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/50 тушаалаар" Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, чиг үүргийн шинжилгээг хийж, холбогдох хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий" Ажлын хэсэг байгуулагдсан. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам УИХ-д хуулийн төсөлд өргөн барьсан. | | |
| 8 | | | 1.2.2.8. Геологи, хайгуулын салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр стратеги, бодлого боловсруулна. | 60% | Геолгийн салбарын хөгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөний төслийг Үндэсний геологийн алба болон салбарын холбоодтой хамтран боловсруулж байна. | | |
| 9 | | | 1.2.2.9. Стратегийн ордуудаас Монгол Улсын хүртэх үр ашгийг нэмэгдүүлэх талаарх холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулна. | 90% | Стратегийн ач холбогдол бүхий Асгатын мөнгөний орд, Төмөртэйн овоогийн цайрын орд, Дорнодын ураны орд, Мардайн ураны орд, Гурванбулагийн ураны орд, Оюутолгойн бүлэг орд, Бороогийн алтны үндсэн орд, Төмөртэй төмрийн хүдрийн 8 ордын талбайн хил, заагийг тогтоон ЗГ-ын тогтоолын төсөл, тэмдэглэл, яамдаас авсан саналын нэгтгэлийг бэлтгэж 2025.04.01-ний 01/950 тоотоор ЗГХЭГ-т хүргүүлэн ЗГ-ын 2025.04.08 өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 170 дугаар тогтоолоор тогтоосон. Стратегийн 16-н ордын хил заагийг тогтоож дууссан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | | | 1.2.2.10. Геологийн мэдээллийн ил тод байдлыг зохих түвшинд хангана. | 90% | "Цогц реформыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох цахим сонгон шалгаруулалтаар хайгуулын тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдийн өмчийн хэлбэр, эзэмшигчийн талаарх дэлгэрэнгүй мэдлээллийг нэгтгэж, сонгон шалгаруулалтын үнэлгээний зарчимд өөрчлөлт оруулах чиглэлээр холбогдох судалгааг хийж байна. Мөн 1997 оноос хойш олгосон ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын хөдөлгөөн, тусгай зөвшөөрлийн өнөөгийн байдлын талаар холбогдох судалгааг гүйцэтгэж, цаашид хэрхэн сайжруулах, хялбаршуулах, чиглэлээр судалгааг хийж байна. ЗГ-ын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны 37 дугаар тэмдэглэлд "2. Ашигт малтмал, газрын тосны газраас 2023.02.28-ны өдрөөс 2024.04.30-ны өдөр хүртэлх хугацаанд олгосон ашигт малтмалын тусгай зөвшөөрлүүд, олгосон захиргааны шийдвэр нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт, шалгалт хийх үүрэг бүхий хамтарсан Ажлын хэсгийг байгуулж, дүнг 2024 оны 4 дүгээр улиралд багтаан ЗГ-ын хуралдаанд танилцуулахыг АҮЭБСайд, ХЗДХСайдад даалгасан.Үүний дагуу 2 яамны хамтарсан Ажлын хэсэг байгуулах тухай албан бичгийн ХЗДХСайдад хүргүүлээд байна. Мөн 2017.11.10-ний өдөр АМТХ-д өөрчлөлт орж 2018.01.01-ний өдрөөс эхлэн дан ганц төрөөс тогтоосон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | талбайд сонгон шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрлийг олгож байна. 2022 онд “Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам”-ыг УУХҮСайдын А/67 дугаар тушаалаар шинэчлэн батлуулж, бүртгүүлсэн. Сонгон шалгаруулалтыг олон нийтэд ил тод, нээлттэй, оролцогч хуулийн этгээдүүдийг өрсөлдөх тэгш боломжоор хангах, субьектив нөлөөллийг багасгах, шалгаруулалтын хугацааг богиносгох, үр дүнг түргэн шуурхай гаргахаар цахим хэлбэрт шилжүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газрын tender.gov.mn платформыг ашиглан тусгай зөвшөөрөл олгож байна. | | |
| 11 | | | 1.2.2.11. Геологи, хайгуулын салбарт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, улмаар ашигт малтмалын нөөцийг өсгөнө. | 90% | Ашигт малтмалын хайгуулын асуудал хэлэлцэх салбар зөвлөлийн 10 удаагийн хурлаар хайгуулын ажлын үр дүнгийн 81 тайланг хэлэлцэж, шийдвэрлэсэн. ЭБМЗ-ийн хурлын дүгнэлт -46, тэмдэглэл-46 хянаж, баталгаажуулсан. Үр дүнгийн тайланд 65 тайланд шинжээч томилуулсан. | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12 | 1.4. Ногоон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангана. | 1.4.2. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ажлын хүрээнд: | 1.4.2.11. Уул уурхай, хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарын ундны гүний усны нөөц ашиглалтыг үе шаттайгаар бууруулж, гадаргын ус ашиглах, усыг дахин ашиглахыг дэмжинэ. | 90% | Судалгаа, шинжилгээний үр дүнд өмнийн говийн ашиглах боломжтой газрын доорх усны нийт 20 ордыг нийгэм, эдийн засаг, байгаль орчны шалгуур үзүүлэлтээр үнэлж, хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн газрын доорх усны ордоос эхэлж ашиглах талаар зөвлөмж өгсөн ба үүнд Өмнийн говийн бүсэд гадаргын усыг шилжүүлэн ашиглах төсөл хэрэгжиж эхлэх хүртэл хугацаанд Загийн усны хоолой болон Цагаан цавын газрын доорх усны ордуудыг ашиглах боломжтойг тодорхойлсон. Тавантолгой ордын үйлдвэрлэлийн болон дэд бүтцийн теслүүдийн усны хэрэгцээг хангахын тулд 280 орчим л/с усны нөөц шаардлагатай бөгөөд энэхүү усны хэрэгцээг Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах “Загийн усны хоолой” болон Дорноговь аймгийн Мандах сумын нутагт байрлах “Цагаан цав”-ын газрын доорх усны ордыг ашиглаж хангахаар төлөвлөж байна. Загийн усны хоолойн ус хангамжийн төслийн барилга угсралтыг 1-р хэсэг ажлыг “НАБСАН” ХХК болон “Тэргүүн Инвест” ХХК-ийн түншлэл, 2-р хэсэг ажлыг “Эс энд Эй Трейд” ХХК болон “Бридж Констракшн” ХХК-ийн түншлэл, -р хэсэг ажлыг “ЧММ” ХХК болон “Сан” ХХК-ийн түншлэлүүд гүйцэтгэн ажиллаж байна. Одоогийн байдлаар нийт төслийн гүйцэтгэл 91 хувьтай байна. “Эрдэнэс Оюу Толгой” ХХК болон “Оюу толгой” ХХК нарын хооронд 2023 оны гуравдугаар сарын 29-ний өдөр байгуулсан “Байгаль орчин, нийгэм, засаглалын | 90 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Түншлэлийн гэрээ"-ний дагуу "Хэрлэн-Тооно" төслийн ТЭЗҮ-ийг шинэчлэх, тодотгол боловсруулах хамтын ажиллагааны хүрээнд "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Э.Ганхүү болон "Оюу толгой" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Дэйрдрэ Лингенфэлдер нар 01/2024 дугаар "Ажлын тодорхойлолт"-нд 2024.05.31-ний өдөр гарын үсэг зурсан бөгөөд "Оюутолгой" ХХК тус төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн төслийг боловсруулах ажилд 3 сая ам. долларын санхүүжилтийг олгохоор төлөвлөсөн. | | |
| 13 | 2.1. Байгалийн баялаг, нөөц, байршлын давуу талд тулгуурласан бүсчилсэн хөгжлийн реформыг хэрэгжүүлнэ. | 2.1.2. Баруун бүсийг "Эрчим хүчний төрөлжсөн бүс бүхий байгалийн аялал жуулчлалын дэд бүс" болгон хөгжүүлэх ажлын хүрээнд: | 2.1.2.2. Асгатын мөнгөний ордын нөөцийг тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах бэлтгэл ажлыг хангана. | 85% | Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /JORC/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө батлагдан хайгуулын ажил хийгдэж байна. | 83.5 | 82.5 |
| 14 | | | 2.1.2.3. Хөнгөн үйлдвэрлэл, технологийн парк, эрдэс, түүхий эдийн нөөцөд тулгуурлан дэвшилтэт технологийн шохойн үйлдвэр, Алтайн нурууны байгаль, соёлын өвийг түшиглэсэн эко парк, цогцолбор байгуулах ажлыг эхлүүлнэ. | 80% | "Хөтөл" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд баригдах Шохой шатаах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Булжих минерал майнинг" ХХК боловсруулж ЭБМЗ өөр 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Т/23-09-08 дугаар дүгнэлтээр батлагдсан. "Урьдчилсан халаагчтай эргэх зуух бүхий технологитой жилд 100 мян.тн хүчин чадалтай шохойн үйлдвэр барих" тендерийн гүйцэтгэгчийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр сонгон шалгаруулсан. Гүйцэтгэгчээр "Сижөн инженерчлэл" ХХК шалгарсан өнөөдрийн байдлаар гүйцэтгэлийн ерөнхий төлөвлөгөө болон топо зураг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | боловсруулагдсан, архитектур төлөвлөлтийн зургын даалгавар авах хүсэлтийг холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн. Мөн мастер төлөвлөгөө боловсруулагдсан ба гүйцэтгэгчийн зүгээс 2025 оны 05 дугаар сард багтаан танилцуулсан. Мөн үйлдвэрийн технологийн түвшний үнэлгээг АҮЭБЯ-ны дэргэдэх Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж хүлээн авахаар шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд “Хөтөл” ҮТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг яамны дэргэдэх Паркийн зөвлөлийн 2025.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. Уг хөгжлийн төлөвлөгөөний дагуу паркт байгуулагдах үйлдвэрийн ажлууд үе шаттайгаар хийгдэх бөгөөд төслийн талбайг хашаалах, ажилчдын түр байр барих зэрэг бэлтгэл ажил хийгдэж байна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | | 2.1.3. **Хойд бүсийг "Байгалийн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс" болгон хөгжүүлэх ажлын хүрээнд:** | 2.1.3.2. **"Эрдэнэт үйлдвэр" төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэсэн үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн төслийг эхлүүлнэ.** | 80% | **Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ нь БНХАУ-ын "China ENFI Engineering" компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Тус ТЭЗҮ-д тооцсоноор төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 762,255.12 ам доллар байх бөгөөд үүний 30%-ийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын хөрөнгөөр, 70%-ийг зээлээр санхүүжүүлэхээр тусгагдсан Зэсийн баяжмал, хайлуулах боловсруулах үйлдвэрийн 2022 онд батлагдсан ТЭЗҮ-д Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс өгсөн зөвлөмжийн дагуу Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрээс гарах хүхэр агуулсан хийг нүүрсээр ангижруулж элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтын үр дүнгээр ТЭЗҮ-ийн тодотгож, холбогдох зөвлөлөөр хэлэлцүүлэх хүсэлтийг "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдөр ирүүлсний дагуу АҮЭБЯ-ны Үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник эдийн засгийн үндэслэл түүний тодотголд дүгнэлт гаргах, зөвлөж өгөх үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж ТЭЗҮ-ийн тодотголыг буцаасан.**<br>**Зэсийн баяжмал, хайлуулах боловсруулах үйлдвэрийг барьж** | | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын техникийн даалгаварыг боловсруулж байгаа бөгөөд техникийн даалгаварын үндсэн үзүүлэлтийн нэг болох төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийн тодотголоор эцэслэн тодорхой болох тул "Зэс боловсруулах цогцолбор" ХХК-иас "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ-ийн тодотголыг батлуулах ажил хүлээгдэж байна. | | |
| 16 | | 2.1.4. Говийн бүсийг "Аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс" болгон хөгжүүлэх ажлын хүрээнд: | 2.1.4.1. "Тавантолгой" үйлдвэрлэл, технологийн паркийг түшиглэсэн кокс-химийн үйлдвэрийн төслийг эхлүүлнэ | 80% | "Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын тухай" Засгийн газрын 2021 оны 113 дугаар тогтоолын дагуу "Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажил гүйцэтгэх" түлхүүр гардуулах нөхцөлтэй тендерт "Norinco International Cooperation" Ltd шалгарч 2022 оны 4 дүгээр сарын 14-нд EPC гэрээг байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдөр тус үйлдвэрийн анхны бүтээгдэхүүн үйлдвэрлэл, туршилт, тохируулгын ажлыг эхлүүлсэн. Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн хөгжлийн төлөвлөгөө болон нэгжийн техник, эдийн засгийн үндэслэлд дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах зөвлөлийн 2025.05.16-ны өдрийн хуралдаанаар Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгойн нүүрсний ордыг түшиглэн барих Кокс-эрчим хүчний үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцүүлж | | 85 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шийдвэрлүүлсэн. “Эрдэнэс ҮТП” ХХК Тавантолгой ҮТП-ийн хүрээнд Кокс-химийн цогцолбор барих техник, эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, паркийн хөгжлийн төлөвлөгөө, холбогдох судалгааны ажлыг гүйцэтгээд байна. “Эрчим хүчний нүүрснээс эцсийн бүтээгдэхүүн гарган авах  туршилтын үйлдвэрийн ТЭЗҮ”-ийг 2023 онд батлуулж, төслийн дагуу хагас үйлдвэрийн туршилтыг мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэхээр 2025 оны төсөвт тусгасан ба Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2025.04.02-ны өдрийн  А/72 тушаалаар төслийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. Нүүрс-хими, Кокс-химийн цогцолборын төслийн бүтээн байгуулалттай холбогдуулан “Бүтээн байгуулалтын зарим төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, 2024.09.19-ний өдрийн 01/493 албан бичгээр яамдын санал авч,  Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан АҮЭБ-ийн сайдын 2024.11.19-ний өдрийн 01/1077 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, Засгийн газрын 2024.11.27-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | | | 2.1.4.2. Тавантолгойн бүлэг ордыг түшиглэн хүнд үйлдвэрлэлийн чиглэлээр үйлдвэрлэл, технологийн парк байгуулах, "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн парк, "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах ажлыг эхлүүлнэ. | 90% | "Инфинити спэйс" ХХК ("Болдтөмөр Ерөө гол" ХХК)-ийн хэрэгжүүлж буй "Алтанширээт" үйдвэрлэл, технологийн парийн хүрээнд 1-1.5 сая тонн хүчин чадалтай төмрийн хүдрийн нойтон баяжуулах үйлдвэр болон нүүрс баяжуулах үйлдвэр, 1.0-2.0 сая тонны хүчин чадалтай коксын үйлдвэр, төмрийн хүдрийн хорголжийн үйлдвэр, ширэмний үйлдвэрийг тус тус барьж байгуулахаар төлөвлөж МУ-ын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ын дагуу Сангийн сайд Б.Жавхлан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, "Алтанширээт" үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхэлж буй "Инфинити спейс" ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Билэгсайхан нар "Татвар төлөх хугацаа сунгах, хэсэгчлэн төлүүлэх гурван талт гэрээ"-г 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Тус гэрээний дагуу паркийн бүтээн байгуулалтад шаардагдах 183 нэр төрлийн 780 тэрбум төгрөгийн өртөг бүхий барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн 39.0 тэрбум төгрөгийн гаалийн татвар, 81.9 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жилээр сунгасан. Бүтээн байгуулалтын нийт ажлын гүйцэтгэл 2025 оны 6 дугаар сарын байдлаар 65%-тай байна. Мөн "Си Өү Эй Эл" ХХК-ийн хэрэгжүүлж буй "Гэрэлт говь" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд жилд 3 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | сая тонн хүчин чадалтай нүүрс баяжуулах үйлдвэрүүдийг үе шаттайгаар барьж байгуулахаар төлөвлөж МУ-ын Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор баталсан. 2025 оны 06 дугаар сарын байдлаар 231 нэр төрлийн бараа материалыг 95,941 сая төгрөгөөр импортлон авч Зүүнбаян-Ханги хүртэлх 22.6 км салбар төмөр зам, 3 сая тонны хүчин чадалтай Нүүрс баяжуулах үйлдвэрийн барилгын үндсэн бүтцийн ажил болон өтгөрүүлэгчийн барилга, тоног төхөөрөмжийн угсралт, цахилгаан холболт, ачилт буулгалтын талбай, нүүрсний агуулахыг барьж дуусган ашиглалтад оруулахад бэлэн болсон бөгөөд ҮТП-ийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 78%-тай байна. | | |
| 18 | | | 2.1.4.6. Говийн бүсийн аж үйлдвэрийг дэмжих хүрээнд тээвэр, логистикийн нэгдсэн сүлжээнд холбох авто замын төслүүдийг хэрэгжүүлнэ. | 85% | Бүсчилсэн хөгжлийн тэргүүлэх чиглэлд говийн бүсийг аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс болгож хөгжүүлэхээр тусгасан. Иймд Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь зэрэг говийн аймгуудын хөгжлийн бодлогыг үүнд нийцүүлж тус тусад нь бус нэгтгэсэн байдлаар шинээр тодорхойлж, "Говийн бүсийн хөгжил-2040" хөтөлбөр, бүсийн зөвлөлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд, бүсийн онцлог, харьцуулалт, тээвэр логистик, тулгамдсан асуудлаар холбогдох байгууллагууд хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан Говийн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар тээвэр логистикийн төв, хуурай боомтыг Даланзадгад, Чойрт, соёл, аялал жуулчлалын тусгай бүс, геопаркыг Дундговь аймагт байгуулахаас гадна говийн бүсийг усаар хангах "Орхон - Онги", Хэрлэн тооно" төслийг үе шаттай хэрэгжүүлэх Засгийн газрын шийдвэр гарч энэ чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байна. Тухайлбал, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтын зэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулж, Өмнөговь аймагт нүүрс-эрчим хүч болон металлургийн кокс, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсэд барилгын материал, түүхий эдийн импортын хангамж, логистикийн төв байгуулна. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | 2.1.5. Төвийн бүсийг "Хөдөө аж ахуйн төрөлжсөн бүс бөгөөд аж үйлдвэрийн дэд бүс" болгон хөгжүүлэх ажлын хүрээнд: | 2.1.5.1. Дархан-Сэлэнгийн бүс нутагт металл боловсруулах болон металл бүтээгдэхүүний үйлдвэр, дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ. | 80% | Дархан-Сэлэнгийн бүс нутагт Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийг хэрэгжүүлж болохуйц 10 байршлыг судлан "Энх тал" зөрлөгийн дэргэдэх талбайд байгуулсан тохиолдолд үүсэх хүндрэл бэрхшээлийг тодорхойлох зорилгоор Инженер-Геологийн урьдчилсан судалгааны ажлыг тухайн газарт хийж гүйцэтгэсэн бөгөөд тус байршлын дэд бүтцийн боломж, ортөө, зөрлөг байгуулах боломж зэргийг Зам тээврийн яамтай зөвшилцсөний үндсэн дээр эцсийн координатыг тодорхойлж 2025 оны 2-р улиралд багтаан газрыг улсын тусгай хэрэгцээнд авхуулахаар ажиллаж байна. Мөн хугацаанд багтаан төслийн стратегийн хамтрагч, түншийг сонгон ЗГ-т танилцуулах ба ингэснээр ТЭЗҮ-ийг хамтран боловсруулах боломж бүрдэнэ. 2025 оны 4-р улиралд багтаан ТЭЗҮ-ийг АҮЭБЯ-ний дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр батлуулахаар төлөвлөж байна. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зүгээс Ган үйлдвэрлэлийн цогцолбор төслийн бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтад хамтран ажиллах боломжит 9 улсын 35 компанид Гадаад хэргийн яамаар дамжуулан хүсэлт хүргүүлсэн бөгөөд 2025 оны 04-р сарын 30-аар эцэслэн санал авсан. Одоогийн байдлаар 2 улсын 9 компани гангийн төсөл дээр хамтран ажиллах сонирхолтой байгаагаа мэдэгдсэн бөгөөд харьцуулсан дүн шинжилгээг Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байгаа. 2025 оны 04 дүгээр сарын 08-15-ны өдрүүдэд БНХАУ-ын төрийн өмчит | | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон хувийн хэвшлийн томоохон Ган үйлдвэрлэлийн 6 компаниатай 2 талын уулзалт хийж, цаашид МУ-д Ган үйлдвэрлэлийн цогцолборыг байгуулахад хамтран ажиллах, хөрөнгө оруулалтын боломжийн талаар санал солилцож, тус компаниудын Гангийн үйлдвэрлэлийн технологитой танилцсан. Хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын дээрх компаниудаас цаашид гүнзгийрэн хамтран ажиллах сонирхлоо илэрхийлж инженер, техникийн ажилтнуудын хамт 2025 оны 07 дугаар сард Монгол Улсад ирж ажиллан, Ган үйлдвэрлэлийн цогцолбор байгуулахаар төлөвлөж буй газартай биеэр танилцан, технологийн шийдлийг нарийвчлан төлөвлөхөөр тогтсон байна. | | |
| 20 | | 2.1.6. Зүүн бүсийг "Түүхэн аялал жуулчлалын төрөлжсөн бүс бөгөөд эрчимжсэн хөдөө аж ахуйн дэд бүс" болгон хөгжүүлэх ажлын хүрээнд: | 2.1.6.3. Зүүн бүсийг Говийн бүстэй интеграцчилан хөгжүүлж, кокс, химийн бүтээгдэхүүн болон нүүрс-эрчим хүчний үйлдвэр, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлнэ. | 90% | Засгийн газраас Зүүн бүсийг Говийн бүстэй интеграцчилан хөгжүүлэх хүрээнд зүүн болон говийн бүсийг аж үйлдвэрийн төрөлжсөн бүс бөгөөд ногоон эрчим хүчний дэд бүс болгон хөгжүүлэх зорилт тавьж байна. Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Дундговь аймгийн хөгжлийн бодлогыг үүнд нийцүүлж, нэгтгэсэн байдлаар шинээр тодорхойлж, "Зүүн болон Говийн бүсийн хөгжил-2040" хөтөлбөр, бүсийн зөвлөлийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, хөрөнгө оруулалт, хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрүүд, бүсийн онцлог, харьцуулалт, тээвэр логистик, тулгамдсан асуудлаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд 2025 | | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | оны 05 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан Говийн бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаанаар тээвэр логистикийн төв, хуурай боомтыг Даланзадгад, Чойрт, соёл, аялал жуулчлалын тусгай бүс, геопаркыг Дундговь аймагт байгуулахаас гадна говийн бүсийг усаар хангах "Орхон -Онги", Хэрлэн тооно" төслийг үе шаттай хэрэгжүүлэх Засгийн газрын шийдвэр гарч энэ чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байна. Тухайлбал, Гашуунсухайт, Шивээхүрэн, Ханги боомтын хэрэглэлийг ахиулж, нэвтрүүлэх хүчин чадлыг сайжруулж, Өмнөговь аймагт нүүрс-эрчим хүч болон металлургийн кокс, бусад дагалдах үйлдвэр бүхий үйлдвэрлэл, технологийн парк байгуулж, Замын-Үүдийн эдийн засгийн чөлөөт бүсэд барилгын материал, түүхий эдийн импортын хангамж, логистикийн төв байгуулна. Засгийн газрын 14 мега төслөөс Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр зам, Нүүрс-хими, кокс-химийн цогцолбор, Газрын тос боловсруулах цогцолборыг барих ажлууд хийгдэж байна. | | |
| 21 | | | 3.1.2.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орд, цементийн үйлдвэрүүдийг түшиглэн барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлнэ. | 85% | "Вестерн Холд" ХХК-ийн хэрэгжүүлж буй Ховд үйлдвэрлэл, технологийн паркт байгуулагдах "Ховд эко цементийн үйлдвэр"-ийн технологийн түвшний үнэлгээг АҮЭБЯ-ны дэргэдэх Хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрдэм шинжилгээний байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бүхий зөвлөлийн 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж, санал, дүгнэлт гаргаж хүлээн авахаар шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд "Ховд" УТП-ийн хөгжлийн төлөвлөгөөг яамны дэргэдэх Паркийн зөвлөлийн 2025.06.13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн хүлээн авсан. | | |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

ХЯНАСАН:
ХШҮДАГ-ЫН ДАРГА Б.ЭНХМӨНХ

ҮНЭЛГЭЭ БОЛОВСРУУЛСАН:
ХШҮДАГ-ЫН МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ